**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ноён сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ӨМА-2022/08/НА-СТА-ТТ3


Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 283

танай ______________-ны №______________ -т

НОЁН СУМЫН ЗАСАГ ДАРГА
О.НАСАНБУЯН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ноён сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ноён сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 43.0 сая төгрөгийг журамд тусгаагүй арга хэмжээнд зарцуулсан, 3.7 сая төгрөгийн албан татварыг суутгаагүй нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтуудыг болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, иж бүрэн байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон зүйл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 0.58 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 0.53 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудлууд**

Бүтцийн өөрчлөлтөөр 2,609.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хөрөнгө, 242.3 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн нь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурахад нөлөөлжээ.

016020389

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2021оны 12-р сарын 31** | **2022 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,132,890.80** | **3,211,916.80** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **1,875,540.00** | **1,063,762.00** |
| **33** | **АВЛАГА** | 169,116.00 | 219,548.50 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **571,834.30** | **329,479.70** |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 1,516,400.50 | 1,599,126.60 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 11,870,135.20 | 9,306,311.70 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **11,870,135.20** | **9,306,311.70** |
| **39200** | **Биет хөрөнгө** | 11,767,284.50 | 9,157,972.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 102,850.60 | 148,339.60 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **16,003,026.00** | **12,518,228.50** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 3,119,267.30 | 5,460,338.00 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 481,449.50 | 600,517.00 |
| **41300** | **Өглөг** | 481,449.50 | 600,517.00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,637,817.80 | 4,859,821.00 |
| **42200** | **Урт хугацаат зээл** | 2,637,817.80 | 4,859,821.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **12,883,758.60** | **7,057,890.50** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 12,883,758.60 | 7,057,890.50 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 3,095,763.30 | 1,546,736.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 3,095,763.30 | 1,546,736.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 0 | 19,946.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 9,107,428.30 | 5,340,030.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 680,567.10 | 151,177.70 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **16,003,026.00** | **12,518,228.50** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2021оны 12-р сарын 31** | **2022 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **7,219,520.10** | **5,711,497.10** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **239,154.30** | **539,671.40** |
| **110** | **Орлогын албан татвар** | 57,617.70 | 192,327.60 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 57,617.70 | 202,280.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | 0 | -9,952.40 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 2,715.00 | 39,598.30 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 178,821.60 | 307,745.50 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,455,471.40** | **1,715,435.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,455,471.40 | 1,715,435.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 5,524,894.40 | 3,456,390.10 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,352,538.40** | **5,668,280.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,352,538.40** | **5,668,280.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,350,700.80 | 4,106,250.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,152,018.00 | 240,062.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 146,690.50 | 30,028.80 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 252,786.90 | 268,888.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 135,285.30 | 88,908.60 |
| **2105** | **Нормативт зардал** | 278,880.60 | 0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 44,714.60 | 76,828.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,480.70 | 6,242.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 175,010.20 | 244,616.10 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,160,834.00 | 3,150,676.30 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,001,837.60** | **1,562,030.00** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **2,866,981.70** | **43,216.60** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **353,590.00** | **0** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **2,513,391.70** | **43,216.60** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **8,507,489.50** | **8,507,489.50** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | 1,862,877.40 | 1,862,877.40 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 10,370,366.90 | 10,370,366.90 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 2,513,391.70 | 2,513,391.70 |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **12,883,758.60** | **12,883,758.60** |
| **11** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **12,883,758.60** | **12,883,758.60** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -5,869,084.80 | -5,869,084.80 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 7,014,673.90 | 7,014,673.90 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 43,216.60 | 43,216.60 |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **7,057,890.50** | **7,057,890.50** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | **6,151,524.90** | **4,622,422.40** |
| **11** | ТАТВАРЫН ОРЛОГО | **239,154.30** | **539,671.40** |
| **110** | **Орлогын албан татвар** | 57,617.70 | 192,327.60 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 57,617.70 | 202,280.00 |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | 0 | -9,952.40 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 2,715.00 | 39,598.30 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 178,821.60 | 307,745.50 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 12,857.10 | 19,109.70 |
| **1181** | **Газрын төлбөр** | 93,243.40 | 234,978.20 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 72,721.10 | 53,657.50 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **450,911.40** | **626,360.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **450,911.40** | **626,360.80** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,461,459.20** | **3,456,390.10** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,616,770.30** | **5,415,180.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,616,770.30** | **5,415,180.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,616,455.40** | **3,742,460.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,237,748.20 | 366,994.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 186,457.40 | 72,382.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 268,043.50 | 324,186.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 274,131.00 | 198,726.60 |
| **2105** | **Нормативт зардал** | 175,328.00 | 200 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 65,077.20 | 72,878.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,480.70 | 6,242.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 132,645.00 | 223,997.20 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 272,544.50 | 2,476,852.60 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,314.90 | 1,672,720.40 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,534,754.60** | **-792,758.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **1,691,140.50** | **19,019.90** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,691,140.50** | **19,019.90** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,691,140.50** | **19,019.90** |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 0 | 0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | -1,691,140.50 | -19,019.90 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 843,614.10 | -811,778.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,031,925.80 | 1,875,540.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,875,540.00 | 1,063,762.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,452,217.7** | **2,661,556.9** | **790,660.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,452,217.7** | **2,661,556.9** | **790,660.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,094,026.9** | **1,001,422.3** | **92,604.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **274,461.6** | **241,039.8** | **33,421.80** |
| 210101 | Үндсэн цалин | 2,009,072.0 | 194,315.2 | **1,814,756.80** |
| 210102 | Нэмэгдэл | 63,528.8 | 39,534.8 | **23,994.00** |
| 210104 | Урамшуулал | 100,256.0 | 7,189.8 | **93,066.20** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **34,308.3** | **30,280.4** | **4,027.90** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,527.2 | 21,007.1 | **2,520.10** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,645.4 | 2,459.1 | **186.30** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,115.9 | 1,951.5 | **164.40** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 628.7 | 440.0 | **188.70** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,391.1 | 4,422.7 | **968.40** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **290,412.9** | **268,888.4** | **21,524.50** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,173.0 | 21,882.2 | **4,290.80** |
| 210302 | Түлш, халаалт | 237,930.5 | 220,796.5 | **17,134.00** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 26,309.4 | 26,209.7 | **99.70** |
| 210304 | Байрны түрээс | 0 | 0 | **0.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **63,955.3** | **63,726.4** | **228.90** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,697.4 | 7,696.8 | **0.60** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,331.1 | 40,331.1 | **0.00** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,765.8 | 5,736.3 | **29.50** |
| 210404 | Ном, хэвлэл | 1,945.0 | 0 | **1,945.00** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,000.0 | 3,000.0 | **0.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,966.5 | 6,962.2 | **4.30** |
| **2105** | **Нормативт зардал** | **208.2** | **200.0** | **8.20** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 208.2 | 200.0 | **8.20** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **61,104.2** | **60,905.7** | **198.50** |
| 210604 | Урсгал засвар | 61,104.2 | 60,905.7 | **198.50** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,360.7** | **6,242.0** | **118.70** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,360.7 | 6,242.0 | **118.70** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **187,352.8** | **187,043.6** | **309.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 187,352.8 | 187,043.6 | **309.20** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **175,862.9** | **143,096.0** | **32,766.90** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 174,216.9 | 141,450.0 | **32,766.90** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,646.0 | 1,646.0 | **0.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,358,190.8** | **1,660,134.6** | **698,056.20** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **2,353,590.8** | **1,655,534.6** | **698,056.20** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 2,353,590.8 | 1,655,534.6 | **698,056.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,600.0** | **4,600.0** | **0.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,600.00 | 4,600.0 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,452,217.7** | **1,801,610.2** | **1,650,607.50** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **0** | **900,318.9** | **-900,318.90** |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 0 | 900,318.9 | **-900,318.90** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,875,428.80** | **855,122.3** | **1,020,306.50** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 975,110.00 | 855,122.3 | **119,987.70** |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 900,318.80 | 0 | **900,318.80** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,576,788.9** | **46,169.0** | **1,530,619.90** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 65,000.0 | 46,169.0 | **18,831.00** |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1,511,788.9 | 0 | **1,511,788.90** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 1,511,788.8 | **-1,511,788.80** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 651,842.1 | **-651,842.10** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **84** | **84** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **16** | **16** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 16 | 16 | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **34** | **34** | |
| 620001 | Удирдах ажилтан | 6 | 6 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 19 | 19 | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **34** | **34** | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10 | 10 | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,321,503.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,321,503.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,313,925.2** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,121.9** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,585.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,516.9 |

| | | |
|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **24,272.3** |
| 210604 | Урсгал засвар | 24,272.3 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,274,530.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,274,530.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,578.1** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **7,567.3** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,567.3 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **10.8** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 10.8 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,321,503.2** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,321,503.2** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,282,532.6 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,620.4 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 31,350.3 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 42.7 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1.5 сая төгрөгийн алдааг залруулж, 41.2 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

- Хөрөнгийн тайлан дахь тусламж хандиваар авсан нийт дүн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 589,200 төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг эх үүсвэртэй нь тулгахад 938,975.61 төгрөгөөр зөрүүтэй байгааг аудитын явцад залруулав*.*

Аудитаар нийт 47.6 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 4.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 43.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Засаг даргын нөөц сангаас 37,178,900 төгрөгийн уралдаан тэмцээнд оролцох, сургалтын төлбөрийн дэмжлэг олгохдоо 3,717,890 төгрөгийн албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна*"-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

### 5.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс урсгал засвар, сумын баяр наадмын бөхийн шагнал, ЭМТ-ийн 90 жилийн ойн арга хэмжээ, зарим иргэдэд өөрийн болгоомжгүй

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үйлдлээс автомашины эвдрэл гаргасан тухай хүсэлтийг шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн, бөхийн цолны мялаалгын дэмжлэг, төрийн албан хаагчдад зөвлөгөөн зохион байгуулсан зардалд 43,000,000 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2 *"Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно*", 6.5 *"нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус хяналт тавина",* 7.1 *"төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна"*-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал

*1.1. Илрүүлэлт:* Тус онд 2.0 төгрөгөөр үл хөдлөх хөрөнгийн орлогыг тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлээгүй нь бүртгэлийн тоо зөрүүтэйгээс төлөвлөлтийн алдаа гарах үр дагавартай байна.

*Өгсөн зөвлөмж*: Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, судалгааг нарийн тооцож бодитой төлөвлөх

*1.2 . Илрүүлэлт:* Тайлант онд малын тоо, толгойн албан татварыг 15,883,200 төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1"Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна",7 дугаар зүйлийн 7.1"Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ний өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө"-гэж заасантай тус тус нийцээгүй нь ИТХ-ын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх үр дагавартай байна.

*Өгсөн зөвлөмж*: Албан татварыг бүрдүүлж ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

*2.1. Илрүүлэлт:* Бараа, үйлчилгээний худалдан авалтын 23,357,000 төгрөгийн төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх"-д заасантай нийцэхгүй байгаа нь дотоод хяналт сулрах үр дагавартай байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх өгсөн зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аудитын явцад заруулах | 2 | 1.5 | | | 1 | 1.5 | 1 | 1.5 | | | | |
| Тус онд 2.0 төгрөгөөр үл хөдлөх хөрөнгийн орлогыг тасалсан | 1 | 2.0 | | | | | | | | | 1 | 2.0 |
| Малын тоо, толгойн албан татварыг дутуу төвлөрүүлсэн байна. | 1 | 15.9 | | | | | | | | | 1 | 15.9 |
| Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж хавсаргасан | 1 | 23.3 | | | | | | | | | 1 | 23.3 |
| **Дүн** | **5** | **42.7** | | | **1** | **1.5** | **1** | **1.5** | | | **3** | **41.2** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдаа, зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Засаг даргын нөөц сангаас зарцуулсан хөрөнгөөс албан татвар суутгаагүй байна | 1 | 3.7 | 1 | 3.7 | | | | | | | | |
| Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 43.0 | | | 1 | 43.0 | | | | | | |
| Дүн | 2 | 46.7 | 1 | 3.7 | 1 | 43.0 | | | | | | |